

“НАЛАЙХЫН ЗАЛУУЧУУД” ДЭД ХӨТӨЛБӨР

“Налайхын залуучууд” дэд хөтөлбөр нь 6 бүлгээс бүрдэнэ.

Нэгдүгээр бүлэг. Ерөнхий мэдээлэл

1.1. Үндэслэл

Монгол улсын Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр, Нийлэлийн залуучууд дэд хөтөлбөр, Налайх дүүргийн Засаг даргын 2017-2020 үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.6 “залуучуудын хөгжлийг дэмжинэ” гэсэн зорилтуудыг тус тус үндэслэл болгов.

2016 оны байдлаар Налайх дүүргийн нийт хүн амын тоо 36425, түүнээс 12936 буюу 35,5 хувийг 15-34 насны залуучууд эзэлж байна. Дүүргийн нийт залуучуудын 6953 буюу 56,3 хувь нь эрэгтэй, 5983 буюу 53,7 хувийг эмэгтэйчүүд байна. Залуучууд бол улс орны хөгжлийг хөдөлгөгч нөөц, эх орондоо ихийг хийж бүтээх суурь хүч нь байдаг. Тиймээс “Налайхын залуучууд” дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх замаар дүүргийн залуучуудыг хамарсан олон талт хөгжлийн үйл ажиллагаа зохион байгуулах, хамтдаа хөгжих, иргэдэд эерэг үлгэр дуурайлал үзүүлэх бүрэн боломжтой юм.

Хоёрдугаар бүлэг. Хөтөлбөрийн зорилго зорилт

Хөтөлбөрийн зорилго

Налайх дүүргийн залуучуудад иргэний ёс суртахууныг төлөвшүүлэх, авъяас чадварыг хөгжүүлэх, дүүргийн хөгжил, бүтээн байгуулалт, тохижилтод залуучуудын оролцоог нэмэгдүүлж, эрүүл чийрэг, оюунлаг, бүтээлч, хуулиар олгогдсон эрх үүргээ ухамсарладаг манлайлагч залуус бүхий дүүрэг болгоход оршино.

2.1 Хөтөлбөрийн зорилтууд

2.1.1 Залуучуудын бодит оролцоог нэмэгдүүлэн, бүтээлч, зөв хандлагатай, соёлч боловсон иргэн болгон хөгжүүлнэ;

2.1.2 Залуучуудыг эрүүл, зөв амьдралын хэв маягт сургаж, гэр бүлийн боловсрол олгож, нийгэмд өрсөлдөх, амьдрах ухааны мэдлэг чадварыг эзэмшүүлнэ;

2.1.3 Залуучуудад мэдлэг боловсрол эзэмших, мэргэжлээ зөв сонгох, сонгосон мэргэжилдээ эзэн нь болохын ач холбогдлыг ойлгуулах сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулна;

2.1.4 Нарийн мэргэжил эзэмшсэн, их дээд сургууль, коллеж төгссөн залуучуудыг ажилд зуучлах, мэргэшүүлэх, ур чадвар эзэмшүүлэх, төрөлх дүүрэгтээ хөдөлмөр эрхлэх нөхцлийг сайжруулах замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ;

Гуравдугаар бүлэг. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Налайх дүүргийн 15-34 насны залуучуудыг хамарна. (ЕБС, Их, дээд сургууль, МСҮТ, бусад залуучууд)

Нэгдүгээр зорилтын хүрээнд:

1. Залуучуудад өөрийгөө хөгжүүлэх, соён гэгээрүүлэх, хариуцлагатай иргэн болгож төлөвшүүлэх зорилгоор хувь хүний хөгжилд чиглэсэн биеэ зөв авч явах болон харилцааны ёс зүйн, хууль эрх зүйн мэдлэг олгох сургалт, сурталчилгаа нөлөөллийн ажил зохион байгуулах, мэдлэг мэдээллээр дамжуулан тэдний хөгжлийг дэмжинэ.

2. Дүүргийн залуучуудад төрөлх монгол хэл, бичгээ сурах, түүх соёл, уламжлалт ёс заншлаа танин мэдэхэд чиглэсэн мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, энэ чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулж байгаа залуучуудыг дэмжинэ.

3. Залуучуудын санал санаачлагаар сайн дурын ажлуудыг зохион байгуулах, ногоон байгууламж, бүтээн байгуулалтад гар бие оролцохыг удирдан чиглүүлж дэмжинэ.

4. Залуучуудын нийгэм, соёл, улс төр, эдийн засаг, иргэний идэвхтэй оролцоог төлөвшүүлж, залуучуудын дунд нийгэмд дагаж мөрдөх амьдралын зөв дадал чадвар олгох аяныг өрнүүлнэ.

5. Залуучуудад чиглэсэн соёл урлагийн үйл ажиллагаа зохион байгуулах, урлаг, спортын чиглэлээр секц дугуйлангууд хичээллүүлэн залуучуудыг хамруулна.

6. Нийтийн бие тамирыг хөгжүүлэх, дүүргийн шигшээ багийг дэмжих, олон төрөлт спортын арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулах замаар залуучуудыг идэвхжүүлнэ.

Хоёрдугаар зорилтын хүрээнд:

1. Өсвөр үе, залуучуудад эрүүл мэндийн анхан шатны мэдлэг олгох (*нөхөн үржихүйн, шүдээ хэрхэн зөв арчлах, зөв хооллолт, дасгал хөдөлгөөн, стрессээс хэрхэн ангижрах, арьсаа хэрхэн зөв арчлах...*) болон гэр бүл төлөвлөлт, (залуу ээж аавуудад болон залуу гэр бүл зөвлөгөө өгөх) бие даан амьдрах мэдлэг чадвар эзэмшүүлэх сургалт нөлөөллийн ажил зохион байгуулна.

2. Дүүргийн өсвөр үе, залуучуудад архи тамхи, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл зэрэг хорт зуршлын хэрэглээний сөрөг үр дагаврын талаар зөвлөгөө өгөх, найз нөхөд, үе тэнгийн хүүхэд задуучуудыг сургагч багш болгон мэргэшүүлж тэднээр дамжуулан сургалт нөлөөллийн ажил зохион байгуулна.

3. Налайх дүүргийн өсвөр үе, залуучуудад иргэний эрх зүйн мэдлэг олгох, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны ажил зохион байгуулна.

Гуравдугаар зорилтын хүрээнд:

1. Дүүргийн ЕБС-ийн ахлах ангийн мэргэжлээ хэрхэн сонгох талаар мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

2. Налайх дүүргийн авъяас, сурлага, урлаг, спортын амжилтаараа үе тэнгийнхнээ манлайлагч залуучуудыг урамшуулах, сургалтын хөтөлбөр, тэтгэлэгт хамруулах ажлыг төрийн болон төрийн бус, аж ахуй нэгж байгууллага, олон улсын байгууллагад холбон зуучлана.

3. Залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, хамтдаа хөгжих, багаар ажиллах, оролцох нөхцөл бүрэлдсэн залуучуудын хөгжлийн төвтэй болно. (Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн дэргэд)

Дөрөвдүгээр зорилтын хүрээнд:

1. Өрсөлдөх чадвараа ашиглан, баялаг бүтээхэд хувь нэмрээ оруулах залуучуудын үүсгэл санаачлагыг идэвхжүүлнэ.

2. Хөдөлмөрийн насны ажил идэвхтэй хайж байгаа залуучуудыг хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс болон бусад аж ахуй нэгж, байгууллагуудтай хамтран ажилд зуучлах үйл ажиллагаа зохион байгуулна.

3. Хөгжлийн бэрхшээлтэй болон нийгмийн халамж, дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай иргэнд үйлчилгээ үзүүлэх залуучуудын сайн дурын ажлыг хөхүүлэн дэмжинэ.

Дөрөвдүгээр бүлэг. Хөтөлбөрийн үр нөлөө, шалгуур үзүүлэлт

4.1 Хөтөлбөрийн үр дүнг өмнөх онуудтай харьцуулан дараах шалгуур үзүүлэлтүүдээр дүгнэнэ.

4.1.1 Хөдөлмөр эрхлээгүй хүн амын дотор залуучуудын эзлэх хувийн бууралт

4.1.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдсан залуучуудын эзлэх хувийн өсөлт

4.1.3 Соёл урлаг, спортын арга хэмжээнд хамрагдсан залуучуудын хамрагдалтын өссөн хувь

4.1.4 Залуучуудын халдварт болон халдварт бус өвчин, шүдний өвчлөлийн бууралт

4.1.5 Залуучуудын эрүүл мэндийн сургалтанд хамрагдсан байдлын өсөлт

4.1.6 Гэмт хэрэг, хэв журмын зөрчилд холбогдсон өсвөр үе, залуучуудын тоон үзүүлэлтийн бууралт

4.1.7 Залуучуудын бүтээн байгуулалт, ногоон байгууламжид оруулсан хувь нэмэр

4.1.8 “Залуучуудын хөгжлийн төв”-өөс зохион байгуулсан үйл ажиллагаа, өсвөр үе залуучуудаас гарсан санал санаачлагын дэмжигдсэн байдлын өсөлт

4.2 Хөтөлбөрийн хяналт үнэлгээг иргэний нийгмийн байгууллагууд болон залуучуудын оролцоотойгоор хийж гүйцэтгэж болно.

Тавдугаар бүлэг. Хөтөлбөрийн санхүүжилт

5.1 Хөтөлбөрийн санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлж, үйл ажиллагааг санхүүжүүлнэ.

5.1.1 Улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилт

5.1.2 Гадаад дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж

5.1.3 Олон улсын байгууллага, тусламж болон төсөл, хөтөлбөрийн санхүүжилт

5.1.4 Бусад эх үүсвэр

Зургаадугаар бүлэг. Хөтөлбөрийн үр дүн

6.1.1 Энэхүү хөтөлбөрийн хэрэгжүүлснээр өсвөр үе, залуучуудын 50 хувь нь нийгэмд дагаж мөрдөх 10 зөв дадал, эерэг хандлага, амьдралын зөв хэв маягийн талаар мэдлэг мэдээлэлтэй болсон байна.

6.1.2 Дүүргийн залуучуудын 45 хувь нь гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүй, эрүүл мэндийн зөв дадал хэвшлийн талаар ойлголт, мэдээлэлтэй болж, эрсдлээс хамгаалах мэдлэг чадвар эзэмшсэн байна.

6.1.3 Ерөнхий Боловсролын Сургуулиудын ахлах ангийн нийт сурагчдыг мэргэжил эзэмших, мэргэжлээ зөв сонгох сургалт сурталчилгаанд хамруулсан байна. Мэргэжил эзэмшсэн залуучуудын 30 хувь нь мэргэшүүлэх болон ажлын ур чадвар эзэмших сургалтанд хамрагдсан байна.

6.1.4 Залуучуудын хөгжлийг дэмжих төв байгуулан, залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, нийгэм соёлын олон талт арга хэмжээнд оролцох нөхцөл боломж бүрдсэн байна.

* * *